



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/11/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11



Г БАЯНТҮМЭН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН Г
ЗАХИРАЛ Ц.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

АХО. 03. 13 № 288

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520202



Үүрэг, хариуцлага

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Болор-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан байгууллага айл өрхийн хог ачилт болон цэвэрлэгээг тогтмол хийж, ахуйн үйлчилгээг хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд 11 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 37,198.6 мянган төгрөгөөс тооцон 743.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,546.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,290.7 мянган төгрөгөөр буюу 45.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	862.8	79.1	783.7
Үндсэн хөрөнгө	412,019.2	616,465.9	204,446.7
Элэгдэл	-83,649.6	-139,021.9	35,372.3
Нийт хөрөнгө	329,232.4	477,523.1	148,290.7
Өр төлбөр	89.1	0.0	89.1
Хуримтлагдсан ашиг	329,143.3	329,143.3	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	148,379.8	148,379.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.0	0.0	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	329,232.4	477,523.1	148,290.7

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгө оруулалтаар болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө орлогод авсантай холбоотой байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 477,523.1 мянган төгрөг болж 148,379.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ нь нийт 21,238.6 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс ажиллагсдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, хог машины тээвэр шатахуун, тээврийн автомашин болон бусад ахуйн үйлчилгээний төсвийн засвар үйлчилгээ болон гэрэл цахилгааны заралд 22,022.3 мянган төгрөгийг зарцуулж, 783.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллахад анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.



2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдөж 100 хувь биелүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	862 793,89	79 053,39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	862 793,89	79 053,39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	862 793,89	79 053,39
3121	Төгрөг	862 793,89	79 053,39
31213	Арилжааны банк дахь харилцах	862 793,89	79 053,39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	328 369 672,74	477 444 048,43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328 369 672,74	477 444 048,43
392	Биет хөрөнгө	328 369 672,74	477 444 048,43
39201	Барилга, байгууламж, орон сууц	55 032 716,49	55 032 716,49
39202	Хуримтлагдсан элэгдэл		(2 844 896,96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37 711 000,00	37 711 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32 473 361,07)	(37 711 000,00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	850 000,00	850 000,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(680 000,00)	(850 000,00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1 830 000,00	1 830 000,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(629 000,00)	(812 000,00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	316 595 494,00	521 042 161,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(49 867 176,68)	(96 803 932,10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	329 232 466,63	477 523 101,82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	89 125,00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89 125,00	-
413	Өглөг	89 125,00	-
4136	Бусад өглөг	89 125,00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	89 125,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	329 143 341,63	477 523 101,82
51	Засгийн газрын хувь оролцоо	329 143 341,63	477 523 101,82
512	Хуримтлагдсан үр дүн	329 143 341,63	477 523 101,82
51210	Өмнөх үеийн үр дүн	379 348 306,56	329 143 341,63
51220	Тайлант үеийн үр дүн	(50 204 964,93)	148 379 760,19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	329 232 466,63	477 523 101,82



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15 476 500,00	225 685 228,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15 476 500,00	225 685 228,00
120	Нийтлэг татварын бус орлого	15 476 500,00	225 685 228,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15 476 500,00	225 685 228,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15 476 500,00	21 238 561,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		204 446 667,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	37 198 597,79	77 305 467,80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37 198 597,79	77 305 467,80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37 198 597,79	77 305 467,80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37 198 597,79	77 305 467,80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14 487 641,65	21 933 176,50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22 710 956,14	55 372 291,30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21 722 097,79)	148 379 760,20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28 482 867,14	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	28 482 867,14	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(28 482 867,14)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(50 204 964,93)	148 379 760,20

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	15 476 500,00	21 238 561,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15 476 500,00	21 238 561,00
120	Нийтлэг татварын бус орлого	15 476 500,00	21 238 561,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15 476 500,00	21 238 561,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15 476 500,00	21 238 561,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	14 723 034,00	22 022 301,50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14 723 034,00	22 022 301,50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14 723 034,00	22 022 301,50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14 723 034,00	22 022 301,50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14 723 034,00	22 022 301,50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	753 466,00	(783 740,50)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	753 466,00	(783 740,50)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109 327,89	862 793,89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	862 793,89	79 053,39



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0,00	0,00	329 143 341,63	0,00	329 143 341,63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00		0,00	0,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
C07	Тайлант үеийн үр дүн					0,00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	329 143 341,63	0,00	329 143 341,63
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		0,00	0,00	0,00	329 143 341,63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	329 143 341,63	0,00	329 143 341,63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00		0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	148 379 760,19	0,00	148 379 760,19
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	477 523 101,82	0,00	477 523 101,82